

Үндэсний хөгжлийн газрын даргын 2018  
оны 06 дугаар сарын 06 өдрийн  
А-92 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт

УХА0588  
6098177  
1116127253

**Гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй  
болгох асуудлаар дүн шинжилгээ хийх, бодлогын санал  
зөвлөмж боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар**

**Зөвлөх үйлчилгээний нэр:** Гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлаар дүн шинжилгээ хийх, бодлогын санал, зөвлөмж боловсруулах нь

**Гэрээний төрөл:** Байгууллага

**Санаачлагч байгууллага:** Үндэсний Хөгжлийн Газар (ҮХГ)

**Даалгаврын хугацаа:** 5 сар (Гэрээнд талууд гарын үсэг зурснаар эхэлнэ)

**1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

1990 оноос Монгол Улсад ардчилал үүсэн ЗХУ-ын холбооны систем задарснаас хойш Монгол Улс нь олон улсын бүх орнуудтай эрх тэгш найрсаг харилцаа тогтоохоор эрмэлзэж ирсэн. XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграц өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Энэ хугацаанд Монгол Улсын эдийн засаг тогтвортой өссөн, чөлөөт зах зээл бий болсон зэрэг сайн үзүүлэлтүүд гарсан. Гэвч Монгол Улсын экспорт импортын бүтцийг авч үзвэл, түүхий эд материал ихээхэн хэмжээгээр гадагшаа, ялангуяа 2 хөрш орнуудад экспортолж, оронд нь нэмүү өртөг шингэсэн бараа бүтээгдэхүүн импортоор авч, боловсруулах салбар нь импортын хамгаалалтгүй байгаагийн улмаас улс орон даяар ажилгүйдэл, ядуурал улам бүр нэмэгдэж, нийгмийн эмзэг байдал хурцдаж улмаар төрийн хямрал үүсэж байна гэж эрдэмтэн судлаачид үзэж шүүмжилж байна.

Монгол Улс 1997 онд ДХБ-д гишүүнээр элсэхдээ авсан амлалтууд нь манай улсын эдийн засаг, түүний дотор боловсруулах салбарын хөгжлийн бодит нөөц, чадамжаас давсан хэтэрхий үндэслэлгүй байсан болох нь өнөөдөр тодорхой болж байна. Ялангуяа дэлхийн хамгийн 2 том гүрний дунд байрладаг, далайд гарцгүй, эдийн засгийн бүтцэд уул уурхай, мал аж ахуй давамгайлсан, өргөн уудам нутаг дэвсгэртэй улмаас аливаа тээвэрлэлт нь өндөр зардалтай, гадаад зах зээлээс ихээхэн хамааралтай, дэлхийн үндсэн зах зээлээс хол, эрс тэс уур амьсгалтай хөгжиж буй улсын хувьд үндэсний боловсруулах аж үйлдвэрүүдээ хамгаалж дэмжсэн уян хатан гадаад худалдааны бодлого, зохицуулалт дутагдаж байна.

Иймд гадаад худалдааны зохицуулалтын өнөөгийн байдал, хууль эрх зүйн орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, гаалийн тарифын хувь хэмжээний үндэслэлийг тогтоох, тарифын бус хориг саадын үндэслэл болон гааль, хилийн хяналт, хорио

цээрийн болон бараа, бүтээгдэхүүний стандартуудыг судлах замаар гадаад худалдааны бодлого, зохицуулалтын шинжлэх ухааны үндсийг боловсруулах, "МУТХҮБ-2030" хэрэгжилтийг хангах, хөгжлийн дунд хугацааны бодлого, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхэд гадаад худалдааны бодлогын зөвлөмж боловсруулах шаардлага гарч байна.

Монгол Улс гадаад худалдааны бодлого, зохицуулалтын уян хатан механизмтай болж, дунд хугацаанд эдийн засгийн бодит салбаруудын тогтвортой хөгжлийг хангасан, үндэсний боловсруулах үйлдвэрүүдийг хамгаалсан, өндөр үр ашигтай гадаад худалдааны бодлого, зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох болно.

Ингэснээр ажилгүйдэл, ядуурлын хэмжээг бууруулж ард иргэд хэрэглэгч буюу бэлэнчлэх сэтгэлгээнээс ангижирч баялаг бүтээгчид болон хөгжлийн үүд хаалга нээгдэнэ гэж үзэж байна.

## **2. АЖЛЫН ЗОРИЛГО**

Зөвлөх үйлчилгээний зорилго нь Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын одоогийн тулгамдсан бэрхшээлтэй асуудлуудыг судлах, дүн шинжилгээ хийж, "МУТХҮБ-2030"-н хэрэгжилтийг хангахад шаардлагатай гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох судалгааг хийх, бодлогын зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, одоо үйлчилж байгаа хууль эрх зүйн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлох, зөвлөмж боловсруулахад оршино.

## **3. ХИЙХ АЖЛЫН ХҮРЭЭ**

Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын өгөх ерөнхий чиглэлийн дагуу гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

1. Монгол Улсын гадаад худалдааны бодлогын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал, хүндрэл бэрхшээлд, дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох, арга замыг тодорхойлох, гадаад худалдааны олон улсын туршлагыг судлаж, Монгол Улсад нэвтрүүлэх боломжийн талаар санал зөвлөмж боловсруулах;
2. Дэлхийн худалдааны байгууллага, түүний гишүүн орнуудад тавьдаг нийтлэг шаардлагууд болон олон улсын худалдаанд ашиглаж байгаа гадаад худалдааны тарифын болон тарифын бус зохицуулалт, ялангуяа экспорт, импортын бараа, түүхий эдэд тавьдаг стандартуудыг судлаж, экспортын бараа бүтээгдэхүүнийг сертификатжуулах, гадны стандартыг нутагшуулах, үндэсний стандартыг бий болгох аргачлалыг судлах;
3. Монгол Улс дотоодын үйлдвэрүүдээ урамшуулах, тэдгээрийн үйлдвэрлэлд шаардлагатай зарим түүхий эдийг боловсруулалтгүй гадаадад экспортлохыг хязгаарлахад гадаад худалдааны тарифын болон тарифын бус зохицуулалтыг (дотоодын зах зээлийн хамгаалалтын механизмууд, демпинг) ашиглах боломжийг тодорхойлох;

4. Гадаад худалдааны уян хатан бодлого зохицуулалтыг бий болгосноор боловсруулах салбар болон эдийн засаг нийгэмд үзүүлэх үр нөлөөг судлах, санал дүгнэлт, зөвлөмж гаргах;
5. "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-г хэрэгжүүлэхэд дэмжлэг болохуйц гадаад худалдааны хуулийн төслийг боловсруулах.

#### 4. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Дээр дурдсан үйл ажиллагааг гүйцэтгэснээр, судалгааны ажил нь дараах үр дүнд хүрсэн байна.

No	Хүрэх үр дүн	Хугацаа
1.	Монгол Улсын гадаад худалдааны бодлого, зохицуулалтын хууль эрх зүйн байдалд шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. Дэлхийн худалдааны байгууллага, түүний гишүүддээ тавьдаг нийтлэг шаардлагууд, олон улсын худалдаанд ашиглаж байгаа гадаад худалдааны тарифын болон тарифын бус зохицуулалт, ялангуяа бараа, бүтээгдэхүүний стандартуудыг судлаж, манай экспортын бараа бүтээгдэхүүнийг сертификатжуулах, гадны стандартыг нутагшуулах, үндэсний стандартыг бий болгох боломжийг судална.	Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дараа
2.	Монгол Улс дотоодын үйлдвэрүүдээ урамшуулах, тэдгээрийн үйлдвэрлэлд шаардлагатай зарим түүхий эдийг боловсруулалтгүй гадаадад экспортлохыг хязгаарлахад гадаад худалдааны тарифын болон тарифын бус зохицуулалтыг ашиглах арга зүйг боловсруулна.	Гэрээ байгуулснаас хойш 60 хоногийн дараа
3.	Гадаад худалдааны бодлого зохицуулалтыг боловсронгуй, оновчтой болгосноор боловсруулах салбар болон эдийн засаг нийгэмд үзүүлэх үр нөлөөг судлана.	Гэрээ байгуулснаас хойш 90 хоногийн дотор
4.	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-г хэрэгжүүлэхэд дэмжлэг болохуйц гадаад худалдааны хуулийн төслийг боловсруулна.	Гэрээ байгуулснаас хойш 150 хоногийн дотор

Дээрх үр дүнгүүд нь ҮХГ-н Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын ахалсан ажлын хэсгээр зөвшөөрөгдсөн байх шаардлагатай ба Монгол хэл дээрх цахим хувилбарыг хүлээлгэн өгнө. Үр дүнг боловсруулах явцын тайланг дараах хугацаанд ирүүлнэ.

	Үр дүнгийн явцын тайлан	Хугацаа
1	Ухлэлийн тайлан	Гэрээ байгуулснаас хойш 25 хоногийн дотор
2	1 дэх явцын тайлан	Гэрээ байгуулснаас хойш 50 хоногт
3	2 дэх явцын тайлан	Гэрээ байгуулснаас хойш 100 хоногт
4	4 үр дүнг боловсруулсан ажлын явцын эцсийн тайлан	Гэрээ байгуулснаас хойш 150 хоногт

## 5. БАГИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

Уг зөвлөх үйлчилгээг хамгийн багадаа 4 зөвлөх бүхий хуулийн этгээд (төрийн бус байгууллага, зөвлөх үйлчилгээний компани эсвэл эрдэм шинжилгээний байгууллага) 5 сарын хугацаанд гүйцэтгэнэ.

## 6. СУДАЛГААНЫ БАГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

**А. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:**

- Гадаад худалдааны бодлого, зохицуулалт, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр мэргэжлийн судалгаа эсвэл зөвлөх үйлчилгээ гүйцэтгэж байсан 5-аас доошгүй жилийн туршлагатай байх;
- Гадаад худалдааны бодлого зохицуулалт болон тэдгээрийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахуйц хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан
- Дэлхийн худалдааны байгууллага, түүний хэлэлцээрүүдийн гишүүн орнуудад тавьдаг нийтлэг шаардлага, техник арга хэрэгслүүдийн талаар шинжилгээ хийх, дүгнэлт гаргах чадвартай байх, ДХБ-ын талаар судалгаа хийж байсан эсвэл зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх;

**Б. Судлаачид нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:**

### 1. Багийн ахлагч/Гадаад худалдааны бодлогын зөвлөх

- Гадаад худалдаа, олон улсын харилцаа эсвэл олон улсын эдийн засгийн чиглэлээр доктор болон түүнээс дээш зэрэгтэй байх;
- Олон улсын байгууллага, төрийн захиргааны эсвэл эрдэм шинжилгээний байгууллагад 10 болон түүнээс дээш жил эдийн засгийн бодлогын чиглэлээр ажилласан туршлагатай байх
- Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрүүд, гадаад худалдааны зохицуулалтын (хөнгөлөлт чөлөөлөлт, хязгаарлалт, хориг, демпинг) талаар мэдлэгтэй байх, энэ чиглэлээр судалгаа шинжилгээ, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байх.
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 талаар ойлголттой байх
- Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулж байсан туршлагатай байх.

- Тайпан, зөвлөмж боловсруулж байсан
- Төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байсан туршлагатай байх.
- Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх.

## **2. Гадаад худалдааны эрх зүй**

- Эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх.
- Олон Улсын эрх зүй, гэрээний эрх зүй, худалдааны чиглэлээр , болон түүнээс дээш жил мэргэжлээрээ ажилласан туршлагатай (Гадаад худалдаа, Тарифын болон тарифын бус зохицуулалт зэрэг дээр ажиллаж байсан бол давуу тал болно).
- Хуулийн төсөл боловсруулж байсан туршлагатай байх.
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 талаар ойлголттой байх.
- Төрийн болон олон улсын байгууллагуудтай ажиллаж байсан туршлагатай байх.
- Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх.

## **3. Олон улсын эдийн засаг чиглэлээр мэргэшсэн зөвлөх**

- Олон улсын харилцаа, олон улсын эдийн засаг эсвэл олон улсын санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх.
- Олон улсын эдийн засаг, олон улсын санхүүгийн чиглэлээр 8 болон түүнээс дээш ажилласан туршлагатай байх.
- Статистик шинжилгээний програм хангамж ашиглаж байсан туршлагатай
- Судалгааны ажил, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэж, тайлан, зөвлөмж боловсруулж байсан туршлагатай байх.
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 талаар ойлголттой байх.
- Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулж байсан туршлагатай.
- Англи, Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэгтэй.

## **4. Гадаад худалдаан дахь стандартчиллын зөвлөх**

- Олон улсын харилцаа, гадаа худалдаа эсвэл, олон улсын эдийн засгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрүүд, гадаад худалдааны зохицуулалтын (хөнгөлөлт чөлөөлөлт, хязгаарлалт, хориг, демпинг) талаар мэдлэгтэй байх, энэ чиглэлээр судалгаа шинжилгээ, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байх.
- Стандартчилал, гаалийн зохицуулалтын чиглэлээр 5 болон түүнээс дээш жил ажиллаж байсан туршлагатай.
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам болон Монгол Улсын

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 талаар ойлголттой байх.

- Тайлан зөвпэмж боловсруулж байсан туршлагатай.
- Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулж байсан туршлагатай байх.
- Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх.

## 7. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛОН ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ

Зөвлөх баг нь ҮХГ-тай гэрээ байгуулах бөгөөд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргад шууд тайлагнана. ҮХГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь зөвлөх үйлчилгээ явуулахад шаардлагатай удирдамж, дэмжлэгээр хангана. Дэмжлэг дараах зүйлсийг багтаах бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй:

- Төрийн болон бусад оролцогч талуудтай холбоо тогтоож өгөх,
- Холбогдох мэдээллийг олж өгөхөд дэмжлэг үзүүлэх
- Оролцогч талуудын уулзалт, зөвлөгөөн хийхэд дэмжлэг үзүүлэх,
- Ерөнхий удирдамж өгөх болон шаардлагатай захиргааны бусад дэмжлэг.
- ҮХГ нь энэхүү даалгаврын үр дүнд зохиогчийн эрх эзэмшинэ.

## 8. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Уг үр дүнг хүлээлгэж өгсөн болон ХБТХ-ийн даргын ахалсан ажлын хэсэг гэрээнд заасан үр дүнг хүлээн авсныг баталгаажуулсны үндсэн дээр олгоно.

Огноо	Төлбөрийн хэсэг	Төлбөрийн нөхцөл
Үр дүн 1:	20%	ҮХГ-ын саналыг тусгаж хүлээж авсны үндсэн дээр
Үр дүн 2:	40%	
Үр дүн 3:		
Үр дүн 4:		